

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022.03.09

№04

Жаргалант

Төлөөлөгчийн ёс зүйн
дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга) 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2.Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ёс зүй, өргөдөл гомдлын хороонд тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.АЛТАНТӨГС

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН “ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нутгийн өөрийн удирдлагын байгууллага болох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын төлөөлөгчийн нийгмийн харилцаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг зохицуулж, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гаргасан зөрчлийг шийдвэрлэхэд энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь улс төр, өөрийн болон өөрт хамаарал бүхий этгээдийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлэхгүй бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлагч мөн тул энэхүү ёс зүйн дүрэм нь төлөөлөгчөөс бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хүлээсэн үүргийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөхөд туслахад оршино.

1.3. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагаа, зөрчлийн болон авлигын эсрэг үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг хангах, төлөөлөгч үйл ажиллагаагаа нийтийн эрх ашигт нийцүүлэн үр дүнтэй ажиллах, манлайллаа сайжруулах нь “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрэм”-ийн үндэслэл мөн.

1.4. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүр энэхүү дүрмийн заалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээх бөгөөд биелэлтэд нь хурлын Ёс зүй, өргөдөл гомдлын хороо дүрэмд заасан үйл ажиллагаа явуулж, ёс зүйн зөрчлийг хянан зохицуулна.

1.5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн ёс суртахууны харилцааны төлөв байдал нь төлөөлөгчийн манлайллын нэг шалгуур үзүүлэлт мөн.

Хоёр. Төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээ

2.1. Төлөөлөгчийн бүрэн эрхийн үйл ажиллагааны ёс зүйн хэм хэмжээ

2.1.1. Төрийн болон бусад байгууллагаас мэдээлэл, туслалцаа дэмжлэг авах, хамтарч ажиллах, төлөөлөгчийн бүрэн эрхийн хүрээний аливаа асуудлаарх үг, үйл ажил, зан харилцаандаа хууль ёсыг дээдлэх;

2.1.2. Үйл ажиллагаандаа нийгмийн тэгш эрх, шударга ёсны зарчмыг баримтлах, төр, олон нийт, иргэдийн холбоог бэхжүүлэх бусдын нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг сахих;

2.1.3. Төрт ёс, түүх, соёлоо нандигнан өвлөн хөгжүүлэх, орон нутгийнхаа хөгжлийн чиглэл хандлагыг үйл ажиллагааныхаа үндэс болгож ажиллах;

2.1.4. Нутгийн удирдлагын болон бусад байгууллага, нийгмийн орчинд холбогдох хууль тогтоомж, журмыг баримтлан биеэ зөв авч явах, бусдад үлгэрлэх;

2.1.5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн хувьд олон нийтийн цахим хэрэгсэл, сүлжээ ашиглахдаа нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх, бусдыг гутаасан агуулгатай санал сэтгэгдэл, зураг дүрс, бичлэг бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл байршуулахгүй байх, өөрийнх нь өмнөөс ийм мэдээ байршуулахаас сэргийлэх;

2.1.6. Төлөөлөгчийн бүрэн эрхээ шашны үйл ажиллагаа болон шашингүйн үзэл суртлын ухуулга, сурталчилгаанд ашиглахгүй байх;

2.1.7. Албан бус зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийг ашиглахгүй байх;

2.1.8. Байгаль орчинд халтай үйлдэл хийхгүй байх, ийм үйлдлийг дэмжсэн санал санаачилга гаргахгүй байх.

2.2 Ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой ёс зүйн хэм хэмжээ

2.2.1. Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг төлөөлөгчийнхөө эрх үүрэгтэй зөрчилдөх нөхцөл байдал бий болгохгүй байх;

2.2.2.Зохих зөвшөөрөлгүйгээр Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжтэй холбоотой асуудлаар гадаадын байгууллага албан тушаалтанд амлалт өгөх, хувийн үзэл бодлоо илэрхийлэхгүй байх;

2.2.3.Өөрийн болон гэр бүлийн гишүүний хувьд ашиг сонирхлын зөрчилтэй аливаа санал хураалтад оролцохгүй байх, нэр хүндээ гэр бүл, ах дүү, садан төрлийн болон хувийн, санхүүгийн, нийгмийн байдлыг дээшлүүлэхэд ашиглахыг хориглох;

2.2.4.Төлөөлөгчийн үүрэг хариуцлагатай харшилсан санхүү, худалдааны болон ижил төстэй ямар ч хэлбэрийн гэрээ, хэлэлцээр, төсөлд оролцохгүй байх

2.2.5.Хүнийг ялгаварлан гадуурхах болон жендерийн тэгш бус байдлыг гаргасан аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх;

2.2.6.Өөрийн нэр хүнд, эрх мэдлийг ашиглаж үнэт цаас, эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх, бусдад давуу эрх олгох үйл ажиллагаа явуулах, оролдлого хийхгүй байх;

2.2.7.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай хувийн харилцаа тогтоох, шууд болон шууд бус тусламж авах, хөнгөлөлттэй үйлчлүүлэх зэрэг хууль бус хангамж эдлэхгүй байх;

2.2.8.Асуудал боловсруулж шийдвэрлэх болон хууль ёсны шийдвэр гаргахад нь бусдад нөлөөлөх, төлөөлөгчид захирагддаг, эсвэл үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг албан тушаалтанд нөлөөлөхийг хориглох;

2.2.9.Хууль бус ашиг хонжоо, давуу тал олох зорилготой үйлдэл хийх, арилжааны зар сурталчилгаанд оролцохгүй байх;

2.2.10.Хууль тогтоомжоор хориглосон, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажил эрхлэх, цалин хөлс өгөх, авахыг шаардахыг хориглох;

2.2.11.Төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашиглахыг хориглох.

2.3 ХОМ, албан томилолттой холбоотой ёс зүйн хэм хэмжээ

2.3.1.Хууль тогтоомжид заасан хугацаа, журмын дагуу хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн, зөв гаргах;

2.3.2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хувиар гадаад, дотоодод томилолтоор явахдаа эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулж, удирдамжийг баримтлах.

2.4 Шагнал, бэлэг дурсгалтай холбоотой ёс зүйн хэм хэмжээ

2.4.1.Төлөөлөгчийн бүрэн эрхийн хүрээнд иргэн байгууллагаас мөнгөн шагнал, шан харамж, хөнгөлөлтэйгээр үйлчлүүлэх, хууль бус бэлэг авахгүй байх, хангамж эдлэхгүй байх;

2.4.2.Хянан шалгаж буй байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан журмаас гадуур бэлэн мөнгө, мөнгөөр үнэлэгдэх үнэт зүйлс авахгүй байх;

2.4.3.Төлөөлөгчийн бүрэн эрхийн хүрээнд олгосон ажлын байр, санхүүгийн эх үүсвэр, холбоо мэдээлэл, тээврийн хэрэгсэл, бусад эд зүйлийг сонгуулийн сурталчилгаа болон улс төрийн намын ажилд ашиглахыг хориглох.

Гурав. Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа

3.1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ёс зүй, өргөдөл гомдлын хороо нь төлөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээний зөрчлийг дор дурдсан нөхцөлд хянан хэлэлцэнэ:

3.1.1.Төлөөлөгч дангаараа эсхүл хамтарч өргөдөл, санал гомдол гаргасан;

3.1.2.Иргэн, хуулийн этгээдээс өргөдөл, санал, гомдол ирүүлсэн;

3.1.3 Ёс зүй, өргөдөл гомдлын хорооны гишүүдийн олонхи нь санал гаргасан.

3.2 Ёс зүй, өргөдөл гомдлын хороо нь төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг баримтлан ёс зүйн асуудлыг хэлэлцэнэ;

3.3 Ёс зүйн зөрчилд холбогдсон төлөөлөгч өөртэй нь холбогдох өргөдөл, санал, гомдолтой бүрэн танилцах, тухайн асуудлаар тайлбар, баримт гаргаж өгөх, хуралдаанд биеэр оролцох эрхтэй.

3.4 Өргөдөл, санал, гомдол ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн төлөөллийг Ёс зүй, өргөдөл гомдлын хорооны хуралдаанд оролцуулах эсэх асуудлыг хорооны гишүүдийн олонхийн санал, иргэн болон төлөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

3.5 Ёс зүй, өргөдөл гомдлын хороо дараахь шаардлагыг хангасан өргөдөл, санал, гомдлыг хүлээж авна:

3.5.1 Өргөдөл, санал, гомдол ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн нэр, албан ёсны болон шуудангийн хаяг, холбогдох утас, факсын дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг, огноо;

3.5.2 Ёс зүйн зөрчилд холбогдсон төлөөлөгчийн эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр, ёс зүйн дүрмийг зөрчсөн талаарх тайлбар, үндэслэл, баримт.

3.6. Ёс зүй, өргөдөл гомдлын хороо өргөдөл, санал, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн төлөөлөгчид танилцуулах ба төлөөлөгч ажлын 10 өдрийн дотор өөрийн тайлбар, баримтыг Ёс зүй, өргөдөл гомдлын хороонд ирүүлнэ.

3.7. Ёс зүй, өргөдөл гомдлын хороо өргөдөл, гомдлыг төлөөлөгчид танилцуулснаас хойш 30 хоногийн дотор гаргасан холбогдох тогтоомжийн шийдвэрээ өргөдөл гомдол гаргасан этгээдэд хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хуулийн дагуу хугацааг сунгаж болно. Давтагдсан тохиолдолд Ёс зүй, өргөдөл гомдлын хороо санал, дүгнэлт гаргаж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

3.8.Өргөдөл, гомдлыг хуулийн байгууллага, эрх бүхий албан тушаалтан шалгаж байгаа бол энэ тухай өргөдөл гаргагчид мэдээлнэ.

Дөрөв. Ёс зүйн хариуцлага ногдуулах

4.1. Ёс зүй, өргөдөл гомдлын хороо нь санал дүгнэлт боловсруулж 30 хоногийн дотор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

4.2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан нь Ёс зүй, өргөдөл гомдлын хорооны санал, дүгнэлтийг хуралдааны дэг болон Төлөөлөгчийн ёс зүйн дүрэмд заасан шаардлагын дагуу хэлэлцэж, дараах хариуцлагын аль нэгийг ногдуулахаар хуралд оролцсон төлөөлөгчийн олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана:

4.2.1.Уучлал гуйхыг үүрэг болгох;

4.2.2.Сануулах;

4.2.3.Өөрийнх нь саналаар чөлөөлөх буюу төлөөлөгчөөс огцруулах;

4.2.4.Хуулийн дагуу холбогдох байгууллагад шилжүүлж хариуцлага тооцох.

4.3.Ёс зүйн хариуцлага ногдуулахдаа нийгмийн шударга ёсны зарчим, ёс зүйн зөрчлийн нийгэмд үзүүлэх хор нөлөө, сумын ИТХ-ын байгууллагын бодлого, үйл ажиллагаа, төлөөлөгчийн нэр хүнд, манлайлал, хариуцлагад харшлах байдал зэргийг харгалзана.

4.4.Төлөөлөгчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн сумын ИТХ-ын хуралдааны шийдвэрийг нийтэд мэдээлнэ.